

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

ын намар



Намар бол цаг агаар ч таатай болдог ба ном унших, зураг зурах, спортын тэмцээн үзэх, өөрөө дасгал хөдөлгөөн хийх гэх мэт сонирхсон зүйлсээ хийх боломжтой болдог. Мөн, усан үзэм, туулайн бөөр, амтат төмс зэрэг намрын амт гэгдэх амттай юм зөндөө! Японд улирал улирал, нутаг нутгаасаа хамааран төрөл бүрийн ургац хурааж үзэх боломжтой байдаг. Та бүхэн сонирхвол явж үзээрэй.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна. (<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)



Болзошгүй тохиолдолд бэлэн байцгаая



Японы өвөл бол агаар хуурайшдаг ба амархан гал гардаг улирал юм. “Засгийн газрын олон нийттэй харилцах онлайн”-д нээлттэй мэдээлэгдсэн “Орон сууцны галаас хамгаалах, Амиа хамгаалахад анхаарах 10 зүйл” (4 заншил + 6 арга хэмжээ)-ийг харж, гэр дотроо гал гаргахгүй байхад анхаараарай.

Орон сууцны галаас хамгаалах Амиа хамгаалахад анхаарах 10 зүйл

4 заншил


1



Болохгүй

Ор, хөнжил дээр хэвтээгээрээ тамхи татаж болохгүй.

2



Болохгүй

Зуухны эргэн тойронд амархан шатах юм тавихгүй байх.


3



Болохгүй

Газан плетка хэрэглэхдээ хажуунаас нь холдохгүй байх.

4



Болохгүй

Залгуурын тоосыг цэвэрлэж, хэрэглээгүй байгаа үедээ залгуураас салгах.

6 арга хэмжээ

1

Гал гаргахгүйн тулд, аюулгүйн төхөөрөмжтэй зуух, газан плетка зэргийг хэрэглэх

2

Галыг түргэн илрүүлэхийн тулд, орон сууцны галын дохиололд тогтмол үзлэг хийж, ойролцоогоор 10 жил тутамд солих

3

Галыг өргөжүүлэхгүйн тулд, өрөөгөө цэгцэлж, гамшгаас сэргийлэх функцтэй ор, гудас, хөнжил болон хувцас, хөшиг хэрэглэх

4

Галыг бага дээр нь унтраахын тулд, гал унтраагч тавьж, хэрэглэх аргыг нь урьдчилан магадлах

5

Дүрвэх маршрут, дүрвэх аргыг урьдчилан магадлах

6

Сургуулилалтанд оролцож, бүсийн комьюнити нийтийг хамарсан галаас сэргийлэх арга хэмжээ авах



政府広報オンライン (https://www.gov-online.go.jp/useful/article/201603/3.html) をもとにJITCOが作成

Том хэмжээний газар хөдлөлт болвол

Япон нь газар хөдлөлт ихтэй орон. Том хэмжээний газар хөдлөлт болсон үед, байшин барилга, тавилга нурж унах аюултай. Мөн, гал түймэр, цунами, хөрсний гулсалт г.м үзэгдэл гарах тохиолдол ч байдаг. Хэрвээ том хэмжээний газар хөдлөлт гарвал, дараах зүйлсэд анхаарч, сандарч тэвдэлгүйгээр тайван хөдлөөрэй.

- ✓ Юуны өмнө, ширээний доор нуугдах г.м биеийнхээ аюулгүй байдгыг хангаарай.
- ✓ Газан плеткийг даруй унтраан, газын хавхлагыг хааж, гал гарахаас сэргийлээрэй.
- ✓ Далай, гол г.м эргийн нутгуудад цунамигийн гамшиг үүсэх аюултай. Дов толгод зэрэг өндөрлөг газар, цунамигаас дүрвэх цамхаг г.м аль болох өндөр газар руу дүрвээрэй.
- ✓ Дүрвэхдээ шилний хагархай, нурж унасан юм, блок хана зэрэг нурж унах юм, тасарсан цахилгаан утас зэргээс болгоомжлоорой.
- ✓ Хорлонтой хуурамч мэдээлэл болон цуу ярианаас болгоомжлоорой. Телевиз, радио, гар утас зэргээс үнэн зөв мэдээлэл цуглуулаарай.
- ✓ Гол чичиргээний дараа дайвар чичиргээ үүсэх тохиолдол их байдаг ба сэтгэлийн хангалттай бэлтгэлтэй байж, бэлэн байхыг хичээгээрэй.
- ✓ Оршин суугаа байр нурж, амьдрах боломжгүй болсон тохиолдолд хоргодох байр руу дүрвэнэ. Сургуулийн биеийн тамирын зал, Комьюнити төв зэрэг нь хоргодох байр болох тохиолдол их байдаг. Хүнсний зүйл, уух юм, адъяал г.м зүйлс тараагдаж, хонуутаар байрлах боломжтой. Олон хүнтэй хамт амьдрах учраас, тогтсон дүрмийг баримтлаарай.

《参考》

「マンガで解説！南海トラフ地震 その日が来たら・・・」(内閣府防災情報) <https://www.bousai.go.jp/jishin/nankai/rinji/pdf/east.pdf>

“Ур чадварын дадлага”-ын оронд “育成就労 (икүсэй шюүроо)” ТОГТОЛЦОО БИЙ БОЛНО.

Q 育成就労(икүсэй шюүроо) тогтолцоо гэж ямар тогтолцоо вэ?

A “Ур чадварын дадлага”-ын тогтолцоо нь гадаадын иргэд Япон улсад ур чадвар эзэмшин, нутаг буцаж эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулдаг тогтолцоо юм. Япон улс энэ оны 6-р сард “Ур чадварын дадлагын тогтолцоо”-ны оронд “育成就労 (икүсэй шюүроо)” гэдэг шинэ тогтолцоог эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Шинэ тогтолцоогоор, Японд ирснээс хойш 3 жилийн хугацаанд “特定技能 /Тусгай ур чадвар”-тай болохуйцаар ур чадвар эзэмшинэ. “特定技能 /Тусгай ур чадвар”-тай ижил салбарт ажил эрхлэх боломжтой. Мөн, шинэ тогтолцоогоор, хэд хэдэн болзлыг хангавал, ижил салбартаа ажил эрхлэх компаниа өөрчлөх боломжтой.

Q Шинэ тогтолцоо хэзээнээс эхлэх вэ?

A 2027 оны 6-р сар гэхэд эхэлнэ.

Q Шинэ тогтолцоо эхэлсэн ч, үргэлжлүүлээд “Ур чадварын дадлага” хийх боломжтой юу?

A Ур чадварын дадлагын хугацаа дуустал Японд дадлага хийх боломжтой.

Q Шинэ тогтолцооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хэнээс асуух вэ?

A Хянан зохицуулагч байгууллага, хүлээн авагч ААН, Бүртгэгдсэн дэмжигч байгууллагын хүнээс асуугаарай. Дэлгэрэнгүй агуулгын талаар JITCO болон Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын вебсайтаар тогтмол бус хугацаанд мэдээлнэ.

Одоогийн шатанд байгаа мэдээллийг тоймлон дээр нэгтгэлээ. Шинэ тогтолцоо эхлээгүй байгаагаас гадна Та бүхний оршин суух статус гэнэт өөрчлөгдөнө гэсэн асуудал байхгүй. Одоогийн статустай хэвээрээ хугацаа дуустал санаа зовох зүйлгүйгээр дадлагаа хийх боломжтой нөхцөл байдал өөрчлөгдөөгүй.

“Тогтолцоо өөрчлөгдсөн”, “Амархнаар өөр компанид шилжин ажиллах боломжтой болсон.” г.м буруу ташаа мэдээлэл түгээж, хууль зөрчихийг турхирдаг хортой хүмүүс ч байна. Мэхлэгдэхгүйн тулд маш сайн анхаарал болгоомжтой байгаарай.

※Мөн, “育成就労(икүсэй шюүроо)”-гийн гадаад хэлний албан ёсны орчуулга нийтэд мэдээлэгдээгүй байна.



Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



ちがうところをたしかめて、正しく書きましょう。

ちがいはどこ?

おお きくて ふと いぬ
おお 大ぜいの ひと が はい たくさん いる。
知らない じ まな ぶ。
きれいな かい を み つけた。
いま あ ったばかりだ。
糸の て ぶくろ
からだ を やす める。
あつめた かず を おし える。
ゆき の ような くも

指導・元世田谷区立
小学校教諭
なかほし れいこ
高橋 伶子
イラスト・奈良 恵



Шинэ цайны навч хураах улиралд цайны тариаланчийнхаар айлчилсан Мьянмарын ур чадварын дадлагажигч нар. Тэрбээр, өөрсдөө цайны навч хурааж үзэн, цайны үйлдвэртэй танилцсанахаа дараа анх удаа мачча (нунтаг ногоон цай) хийж, амтлаг амтаны хамт хүртжээ. Үзэсгэлэнт ногоон цайны модны талбайн дунд тэдний инээмсэглэж буй зураг.

※2024年6月投稿 実習実施者：社会福祉法人 同和園

Оролцохыг урьж байна.

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



JITCO нь “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 32-р уралдаан”-ыг зохион байгуулж, шагналын эздийг JITCO-гийн цахим хуудсаар зарласан. Шилдэг бүтээлийн цомгийг ч цахим хуудсандаа жич байршуулна. Та бүхнийг сонирхон харахыг урьж байна.



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

Асуудал тулгарсан үед ...? (<https://www.otit.go.jp/notebook/>)

OTIT (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばのにほんご/Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



◆ こくごことえ

大 きくて 太 った 犬 いぬ
大 ぜいの 人 が 入 っ て い く。
知 らない 字 を 学 ぶ。
きれいな 貝 を 見 っ た。
今、会 っ たばかりだ。
毛 糸の 手 ぶくろ
体 を 休 める。
集めた 数 を 教 える。
雪 のような 雲

「見」は目と儿（ひと）の組み合わせですが、「貝」は子安貝の形で、ひととは別の成り立ちです。その他の漢字も、どこかが同じでどこかが違います。「大」は手足を広げて立つ姿、「犬」は走っている犬をたてに描いた形、「太」は両手でたっぷり水を流す様子を表す「泰」が元の字です。

「こ」の位置、画の数やつき方、反りと曲がりなど、正しく書き分けられましたか。

“、”-ын байрлал, ханзны зурлагын тоо болон зурлагын холболт, нугалаа болон эргүүлэг гэх зэргээр зөв ялгаж бичиж чадсан уу? “見” бол “目”, “儿(ひと/хито)”-г нийлүүлсэн ханз боловч “貝” бол “子安貝/хясаа”-ны хэлбэртэй ба “ひと/хито”-гоос өөр үүсэл гаралтай. Бусад ханзнууд ч гэсэн, зарим хэсэг нь ижилхэн, зарим хэсэг нь өөр. “大” бол гар хөлөө тэнийлгэж зогссон хүний байдлыг дүрсэлсэн, “犬” бол гүйж байгаа нохойг босоо хэлбэрээр дүрсэлсэн хэлбэр, “太” бол хоёр гараараа зөндөө ус асгаж байгаа байдлыг илэрхийлсэн “泰” ханзнаас гаралтай.

とも

2024年10月 秋季号

2024年10月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

03-4306-1166 (ダイヤルイン)

<https://www.jitco.or.jp/>

電話

JITCO ホームページ